

АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн асуудал эрхэлсэн хороо 4 дүгээр сарын 22-ны өдөр хуралдаж “Өрх бүр үйлдвэрлэгч” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцсан бөгөөд дэд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг дэлгэрэнгүй тайланд тусгах талаар чиглэл өгч, дахин хуралдахаар шийдвэрлэсэн.

Хурлын Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны хуралдаанаар Төрийн үйлчилгээнд “Цахим шилжилт”-ийг үе шаттай хийж, цахим засаглалд шилжих үйл ажиллагаатай танилцах тухай, “Стандарттай Архангай” арга хэмжээг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын тамгын газар болон төрийн байгууллагуудад “Чанарын удирдлагын тогтолцоо /ISO- 9001:2015/-г нэвтрэлтийн үйл явцтай танилцах тухай, Музейн гурван үзмерийг Чингис хааны музейрүү шилжүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэж, хуралдаанаас гарсан санал дүгнэлтийг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн удирдах ажилтны зөвлөгөөнийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын сургалтын танхимд зохион байгуулж 3 дугаар сард өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг танилцуулж, аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газраас цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ.

Мөн энэ өдөр аймгийн Засаг дарга М.Батжаргал байгууллагын дарга нарт холбогдох үүрэг даалгавар болон анхаарах ажлын чиглэлийг өгсөн.

2022 оны 4 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан төрийн албаны ерөнхий шалгалтад 232 иргэн оролцохоор бүртгүүлснээс 201 иргэн шалгалт өгч, оролцогчдын 35.8 хувь буюу 72 иргэн шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн.

2022 оны хаврын ээлжит цэрэг татлага 4-р сарын 27-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд явагдаж байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлт

Аймгийн төсвийн орлогод өссөн дүнгээр **623,127,6** мянган төгрөг төвлөрүүлэхээс **898,379,0** мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 2022 оны 4 дүгээр сарын 29-ний байдлаар 144.2 хувийн биелэлттэй байна.

Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 2022 оны 3 дугаар сарын гүйцэтгэлээр, торгуулийн орлого 120 хувиар буюу 39.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 253.8 хувиар буюу 59.1 сая төгрөгөөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр 117.3 хувиар буюу 651 мянган төгрөгөөр тус тус давж, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 98.2 хувиар буюу 29.1 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын татвар 75.5 хувиар буюу 19.3 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн татвар 28.9 хувиар буюу 177 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 81.2 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр, газрын төлбөр 21.1 хувиар буюу 52.0 сая төгрөгөөр тус тус тасарсан үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулалт

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 87922.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 116033.6 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. 27 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг

100 хувь зохион байгуулсан. 85133.6 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгосон байна. 29406.5 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан. 15917.8 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулах эрх олгож, хуулийн дагуу гэрээ байгуулах хугацааг хүлээж байгаа бол 1250.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээнд шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй тул дахин тендер зарлаж, 30000.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээнд Сангийн яаманд гомдол гарсан, 39459.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний үнэлгээ хийгдэж байна.

Байгаль орчин, аялал жуучлалын яамнаас 200.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн. Тендерийг зарласан боловч шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй тул тендерийг дахин зарласан.

Санхүүгийн хяналт

Боловсролын салбарын бүтэц орон тоо, цалингийн сангийн гүйцэтгэлд дотоод аудит, “Ар Ус Ундарга” ХХК-ний 2020-2022 оны эхний 3 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт тус тус хийгдэж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

Аймгийн хэмжээнд 2022 оны 4 дүгээр сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 7 удаа гарсанаас: Объектын гал түймэр 4, хээрийн гал түймэр 1, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага 2, зам тээврийн осол 1, иргэний хүсэлт 4, малын гоц халдварт өвчин 1, хүний гоц халдварт /ковид-19/ өвчин 1 тус тус гарч аюулт үзэгдэл ослын улмаас 2 иргэн нас барж 1 гэр орон шатаж 78.0 сая төгрөгийн хохирол учирсан байна.

2022 оны 04 дүгээр сард коронавируст халдвар “Covid-19”-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын даргын тушаал, хурлын тэмдэглэл, албан даалгавар, аймгийн Засаг даргын захирамжаар “Гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлын зэрэг **Шар түвшин**”-д шилжин ажиллаж, Шуурхай штабт 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Аймаг, орон нутгийн хэмжээнд Коронавируст /Ковид-19/ын халдвараар өвчилсөн иргэдийг Нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлгүүд болон 18 сумын эрүүл мэндийн төвүүдийн тусгайлсан эмнэлэгт тусгаарлан эмчилгээ хийж, Эрдэнэбулган сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хөнгөн туссан иргэдийг гэрээр тусгаарлан эмчилгээ хийж ажиллаж байна. Халдвар авсан иргэдийн ойрын хавьтлуудыг тандалт судалгаа хийж илрүүлэн “PCR” болон Түргэвчилсэн тестээр шинжилгээг авч гэрээр тусгаарлан давтан шинжилгээ авч шинжилгээний хариуг үндэслэн дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байна.

2022 оны 4 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт **187** гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 46, хулгайлах гэмт хэрэг 68, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 22, малын хулгайн гэмт хэрэг 41, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 32, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 11, гэмт хэргийн улмаас нас барсан иргэн 7, гэмт хэргийн илрүүлэлт 51.0 хувьтай байна.

Нийт 8055 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 7669 иргэнд **312.5** сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 539.9 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.7 хувьтай байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл улсын хэмжээнд www.eec.mn цахим хуудсаар 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд явагдсан бөгөөд Архангай аймагт 1064 шалгуулагч

Элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн байна. Үүний 764 нь хичээл сонголтоо хийж бүрэн баталгаажуулсан. Өмнөх оны төгсөгч 194 бүртгүүлсэн байна.

"Good School" сургалтын байгууллагатай хамтран 2021-2022 оны хичээлийн жилийн 12-р ангийн сурагчдад ЭЕШ-ын хичээлүүдээр сургалтын үйл ажиллагаа явуулж, ЭЕШ-д бэлдэж байна. Уг сургалтад 876 сурагч 1751 хичээлд хамрагдаж байна.

Сургалтын төлбөрийн 50 хувийг аймгийн Засаг даргын зүгээс шийдвэрлэн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.

Монгол хэл бичгийн шалгалтыг 4 дүгээр сарын 2-ны өдөр улс орон даяар нэгэн зэрэг зохион байгууллаа. Монгол хэл бичгийн эхний удаагийн шалгалтад Архангай аймгаас 1043 шалгуулагч бүртгүүлснээс 936 шалгуулагч шалгалтад орж, Монгол хэл бичгийн шалгалтын босго 400 оноо бөгөөд 797 шалгуулагч уг босго оноог давсан байна.

Соёл урлаг

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 14 уншигч шинээр бүртгэж, 354 ирэгсэдэд 485 ном, хүүхдийн уншлагын танхимаар 91 уншигч шинээр бүртгэж, 1173 ирэгсэдэд 2140 ном олгож тус тус үйлчилсэн байна.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар сард нийт 83869 үзлэг хийснээс 23066 буюу 27.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна. Нийт үзлэгийн 44 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд, 36 хувь нь Нэгдсэн эмнэлэгт, 18 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, 2 хувь нь хувийн эмнэлгүүдэд бүртгэгдсэн байна.

2022 оны 3 сард 308 эх төрсөн нь өнгөрсөн оноос 118 тохиолдлоор буурсан байна. Нийт төрөлтийн 78 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 22 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд төрсөн.

Хүн амын нас баралтын 127 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгаанд зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөлийн нас баралт 48/37,8%, хорт хавдарын нас баралт 37/29%, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 18/14% тохиолдлоор тэргүүлэх шалтгаан болж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 3 сарын байдлаар цочмог халдварт өвчний нийт 4256 тохиолдол бүртгэгдсэнээс коронавируст халдварын нийт 4250 /99,8%/ тохиолдол бүртгэгдсэн.

Архаг халдвар өвчин 38 тохиолдол бүртгэгдсэнээс 21% нь сүрьеэ, 79 % нь БЗДХ байна.

2022 оны 4 дүгээр сарын 27-ны байдлаар нийт PCR шинжилгээнд 9637 хүнийг, түргэвчилсэн шинжилгээнд 5608 хүнийг хамруулж, 4270 батлагдсан тохиолдлыг илрүүлж, тусгаарлан эмчилгээнд хамруулсан.

Вакцинжуулалтын 23 цэгт коронавирүсийн эсрэг вакцинжуулалтын 1 дүгээр тунд 60768, 2 дугаар тунд 57524, 3 дугаар тунд 26851, 4-р тунд 2088 хүнийг хамруулаад байна.

Биеийн тамир, спорт

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж буй "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аян орон даяар 2022 оны 02 дугаар 29-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулагдана. Архангай аймагт 32 дахь өдрөө үргэлжилж байна. Аймгийн цэцэрлэг, сургууль, албан байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 35 байгууллага идэвхтэй хамрагдаад байна. БТСГ-ын заал, фитнес танхим, 19 сумын сургуулийн зааланд албан байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчид, сургууль цэцэрлэгийн ажилтан, ЭБ сумын багийн иргэд өглөөний дасгал хөдөлгөөнд хамрагдан, давхардсан тоогоор 4000 хүн хамрагдаад байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2022 оны 4 дүгээр сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1177 иргэн бүртгэлтэй байгаагаас 566 эмэгтэй. Шинэ ажлын байр 95, үүнээс байнгын ажлын байр 95 байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Нийт 19 суманд 67 ажлын хэсэгт 435 хүн ажиллаж **628851** малыг /үхэр, гахай/ вакцинд хамруулахаас **413099** мал хамруулж, вакцинд хамрагдалт 65.6 хувьтай, үлдэгдэл вакцин **216901** тун байна.

Аймгийн хэмжээнд энэ онд мал тооллогын дүнгээр 5,562.0 мянган толгой мал өвөлжиж, хаваржиж байна.

Сумдын нөөц бүрдүүлэлт өвс, ногоон тэжээл 1855.2 тн, тэжээл 367.2 тн байснаас одоогоор сумдын нөөцөд 1670 тн өвс, ногоон тэжээл, 330 тн тэжээл байна.

Аймгийн аюулгүй нөөцөд 100 тн өвс, 341.6 тн ногоон тэжээл, 55.8 тн гар тэжээл байна.

Аймгийн хэмжээнд нийт **2.4** сая толгой хээлтэгч мал тооллогдсоноос төллөвөл зохих **2.1** сая толгой хээлтэгч малын **73.2** хувь буюу **1.5** сая гаруй толгой хээлтэгч мал төллөж **1.5** сая толгой төл мал **97.3** хувьтай бойжиж байна.

Үүнээс төллөсөн хээлтэгч ингэ 136 буюу 30.8 %, гүү 14476 буюу 13.0 %, үнээ 72601 буюу 31.8 %, эм хонь 1007234 буюу 84.8 % эм ямаа 450156 буюу 77.5 хувь нь, нийт бог малын хээлтэгчийн 82.5 хувь, бод малын хээлтэгчийн 25.5 хувь нь төллөсөн байна.

Аймгийн хэмжээнд 5.5 сая толгой мал тооллогдсоноос нийт мал сүргийн 0.4 хувь буюу 19.9 мянган толгой мал хорогдсон.

Газар тариалан

2022 онд газар тариалангийн үйлдвэрлэл аймгийн хэмжээнд төмс 275 га, хүнсний ногоо 166 га, жимс жимсгэнэ 80 га, малын тэжээл 4100 га, тосны ургамал 600 га талбайд тариалахаар төлөвлөөд байна.

Үр тарианы үйлдвэрлэлийг 7965 га уриншинд, 4283 га гуурсанд, нийт 12248 га талбайд үр тарианы үйлдвэрлэл эрхлэхэд 2082 тн үр шаардлагатайгаас 1144 тн нөөцөлж, 938 тн үр, 122,48 тн шатахуун, 1048 тн бордоо, 1921 литр ургамал хамгааллын бодисын захиалгыг хүргүүлсэн.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн 8 нэгж, байгууллагад 93.0 мянган тарьц суулгацын нөөц байна. Сумдад тарьц суулгацын нөөц тодорхой хэмжээгээр байгаа. Мөн Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүд 430.0 мянган тарьц суулгацыг манай аймагт худалдах сонирхлоо илэрхийлсэн байгаа.

Эрдэнэбулган сумын нийтийн эзэмшлийн талбайд ургаж буй мод, сөөгний нарийвчилсан судалгааг гаргаж 34 цэцэрлэгт хүрээлэнд шинэс, улиас, гацуур, нарс, хайлаас, бургас, шархуайс, агч, гүйлс, хуш, голт бор зэрэг нийт 11 нэр төрлийн 26414 мод, сөөг ургаж байна. Насжилтын хувьд хамгийн бага нь 5 настай, дээд тал нь 5-85 жилийн настай мод 48 га талбайд байна

Барилга, дэд бүтэц, газар

Архангай аймагт 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 4 дүгээр сард орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 14 барилгын барилга угсралтын ажлын явцад захиалагчийн хяналтыг хийж гүйцэтгэсэн.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----